# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
# ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 31 өдөр Дугаар 89 Номгон

Нутгийн удирдлагын шинэ тогтолцоо үүсч
хөгжсөний 25 жилийн ой тэмдэглэх тухай

Монгол Улсын шинэ Үндсэн хуулиар баталгаажсан Нутгийн удирдлагын шинэ тогтолцоо үүсч хөгжсөний 25 жилийн ойг аймаг орон нутагтаа тэмдэглэн өнгөрүүлэх тухай хэлэлцээд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Монгол Улсад Нутгийн удирдлагын шинэ тогтолцоо үүсч хөгжсөний 25 жилийн ойг 2017 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Баянхонгор аймагт зохион байгуулсугай.

2. Ойн хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3. Ойн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Ц.Отгонбаяр-Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга

Орлогч дарга Г.Батжаргал-Аймгийн Засаг дарга

Нарийн бичгийн дарга С.Үнэнбуян-Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга

Гишүүд Н.Оюун-Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгч

Э.Энхбат-Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгч

Э.Цэнд- Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгч

Т.Бат-Очир-Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч

Л.Баасанбат-Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч

Т.Очирбал-Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч

Л.Баясгалангомбо-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга

М.Батбаяр-Баянхонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга

М.Мэнджаргал-Аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга

П.Санаадагва-"Өнөөгийн Баянхонгор" сонины эрхлэгч

0117239

4. Нутгийн удирдлагын шинэ тогтолцоо үүсч хөгжсөний 25 жилийн ойг төлөвлөгөөний дагуу тогтсон хугацаанд зохион байгуулалтын өндөр хэмжээнд удирдан явуулахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга С.Үнэнбуян, ажлын хэсэгт даалгасугай.

ДАРГА Ц.ОТГОНБАЯР

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 05 дугаар сарын
31-ний өдрийн 89 дүгээр тогтоолын хавсралт

## МОНГОЛ УЛСАД НУТГИЙН УДИРДЛАГЫН ШИНЭ ТОГТОЛЦОО ҮҮСЧ ХӨГЖСӨНИЙ 25 ЖИЛИЙН ОЙН ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хэрэгжүүлэх ажил | Хариуцах эзэн | Хамтран хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтан | Хэрэгжүүлэх хугацаа | Гарах үр дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1 | Нутгийн удирдлагын шинэ тогтолцоо үүсч хөгжсөний 25 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөө батлах, ажлын хэсэг байгуулах | Зохион байгуулалтын хэлтэс | Ажлын алба | 3-р улирал | Тогтоол батлагдан гарснаар |
| 2 | Нутгийн удирдлага сэтгүүлийг ИТХ-ын төлөөлөгчдөөр захиалуулж гарын авлага болгох /2052 ширхэг/ | Зохион байгуулалтын хэлтэс | Ажлын алба | Жилдээ | Нутгийн удирдлага сэтгүүл захиалагаар улсын хэмжээнд 1 дүгээр байрт орсон байна. |
| 3 | Нутгийн удирдлагын шинэ тогтолцоо үүсч хөгжсөний 25 жилийн ойн номд оруулах сумдын ИТХ-ын материалыг хүлээн авч МНУХолбоонд хүргүүлэх | Зохион байгуулалтын хэлтэс | Ажлын алба | 1-3-р улирал | 25 жилийн ойн номд сумдын ИТХ-ын материал бүрэн орсон байна. |
| 4 | Нутгийн удирдлагын шинэ тогтолцоо үүсч хөгжсөний 25 жилийн ойг аймагтаа зохион байгуулах /тусгай хөтөлбөрөөр/ | Зохион байгуулалтын хэлтэс | Ажлын алба | 3-р улирал | 25 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн байна. |
| 5 | Аймгийн ИТХ-ын даргаар ажиллаж байсан хүмүүсийн зургийг Нутгийн удирдлагын ордонд хүндэтгэлтэйгээр байрлуулах | Зохион байгуулалтын хэлтэс | Ажлын алба | 2-р улирал | Зургийг Нутгийн удирдлагын ордонд хүндэтгэлтэйгээр байрлуулсан байна. |
| 6 | Хүндэтгэлийн концерт тоглох /Аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, ажлын алба/ | Ажлын алба | Ажлын алба | 3-р улирал | Хүндэтгэлийн концерт тоглосон байна. |
| 7 | Хүндэтгэлийн хурал хийх | Ажлын алба | Ажлын алба | 3-р улирал | Хүндэтгэлийн хурал хийсэн байна. |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| 8 | Зургийн үзэсгэлэн гаргах | Ажлын алба | ИТХ-ын харъяа өндөр настнууд | 3-р улирал | Үзэсгэлэн гарган нийтэд сурталчилсан байна. |
| 9 | 25 жилийн ойд оролцогчдод бэлэг дурсгалын зүйл бэлтгэх | Ажлын алба | Ажлын алба | 3-р улирал | Бэлэг дурсгалын зүйл бэлтгэсэн байна. |
| 10 | Нутгийн удирдлагын шинэ тогтолцоо үүсч хөгжсөний 25 жилийн ойн сэтгүүлийн эхийг бэлтгэн хэвлүүлэх | Ажлын алба | Ажлын алба | 3-р улирал | Ойн сэтгүүл хэвлүүлсэн байна. |
| 11 | Аймаг, сумдын ИТХ-ын төлөөлөгчдийн “Төлөөлөгчийн өдөр” арга хэмжээг зохион байгуулалттайгаар хийх | Ажлын алба | Сумдын ИТХурал | Жилдээ | Төлөөлөгчдийн тойрогтоо ажиллах боломжийг хангаж, хамтран ажилласан байна. |
| 12 | Хөрш аймгуудтай хамтран, НӨУБ-уудын туршлага солилцох уулзалтуудыг зохион байгуулах | Ц.Отгонбаяр С.Үнэнбуян | Ажлын алба | Жилдээ | Тэргүүлэгчдийн ажлын албаны ажилтнууд, Төлөөлөгчдийг чадавхжуулсан байна. |
| 13 | Сумдын ИТХ-ын үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, зөвлөн туслах ажлыг бүх сумдыг хамруулан зохион байгуулах | Ажлын алба ОНХХ | Ажлын алба | Жилдээ | Зөвлөн туслах ажлыг зохион байгуулсан байна. |
| 14 | Улаанбаатар хотын Чингэлтэй, Хан Уул дүүргийн ИТХ-ын ажлын албатай хамтран ажиллах, харилцан туршлага солилцох | С.Үнэнбуян | Чингэлтэй, Хан-Уул дүүргийн ИТХ-ын ажлын алба | Жилдээ | Харилцан туршлага солилцон хамтын ажиллагаа өргөжсөн байна. |
| 15 | Нутгийн удирдлага 25 жил баримтат кино хийх, хэвлэл мэдээллээр сурталчилах | С.Үнэнбуян | Ажлын алба | Жилдээ | Баримтат кино хийгдэж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан байна. |
| 16 | Орон нутгийн аялал хийх | С.Үнэнбуян | Ажлын алба | Жилдээ | Аялал зохион байгуулагдсан байна. |
| 17 | Аймгийн ИТХ-ын төлөөлөгч нар орон нутагт ИТХ-ын байгууллагын үйл ажиллагааг сурталчилах | С.Үнэнбуян | Ажлын алба | Жилдээ | Төлөөлөгч нар орон нутагт ажилласан байна. |
| 18 | Байгууллагын дарга нарын дунд спорт өдөрлөг зохион байгуулах | С.Үнэнбуян | Ажлын алба | Жилдээ | Спорт өдөрлөг зохион байгуулагдсан байна. |
| 19 | Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийг 3 дугаар шатлалын эмнэлэгт эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах | С.Үнэнбуян | Ажлын алба | Жилдээ | Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байна. |

__________o0o__________